



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/537

Зуунмод

Санхүүжилт гаргах тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Засаг даргын нөөц сангийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 3.1, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үеийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний үйл ажиллагаанд тавих хяналтын сайжруулах зорилгоор аймгийн Мэргэжлийн хяналтын газарт автомашин худалдан авахад 52,800,000 (тавин хоёр сая найман зуун мянга)-төгрөгийн санхүүжилт гаргасугай.

2. Санхүүжилтэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), Засаг даргын Тамгын газар (С.Магнайбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Санхүүжилт

13/IX